

**БНМАУ-ЫН ОЛОН УЛСЫН СТАТУСЫГ ХҮЛЭЭН
ЗӨВШӨӨРӨХ НЭГДСЭН ВАНТ УЛСЫН БОДЛОГО:
СТАТУС КВОГООС ДЕ-ЮРЕ ХҮРТЭЛ**

Д.Уламбаяр*

Товч утга:

Монгол Улсын олон улсын статусын талаарх Нэгдсэн Вант Улсын байр суурь, тэр нь статус-квог хүлээн зөвшөөрөхөөс эхлэн хамтаар хүлээн зөвшөөрөх үйл, де-факто, цаашлаад де-юре хүртэл хэрхэн хувиран өөрчлөгдөж, ахин дэвшиж ирсэн тухай өгүүлнэ.

Түлхүүр үг: Ноот бичиг, Ялтын нууц хэлэлцээр, статус-кво, НҮБ, Аюулгүйн Зөвлөл, Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүд, вето, де-факто, де-юре

Удиртгал

1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын удирдагчид хоёр хөршөөсөө гадна «гуравдагч хөрш»-тэй харилцаа тогтоохыг чинхүү эрмэлзэж байсан нь гадаад улс төр, эдийн засгийн бодлогын чухаг чиг шугам байжээ. Энэ нь юуны өмнө Өрнө, Дорны гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, улмаар тэдгээр орнуудтай худалдааны өргөн харилцаа холбоо тогтоох, Өвөрлөгч нутгийг Халхад нэгтгэх замаар Монгол үндэстний улс төрийн нэгдлийг хангах, түүнийгээ бататгах үндэсний эрх ашиг хийгээд аюулгүй байдалтай ямагт холбогдож байв. 1912 оны 11 дүгээр сард Монгол Улсын ГХЯ-наас ноот бичиг үйлдэн «Их Фа (Франц), Ин (Англи), Дэ (Герман), Мэй (АНУ), Билиш (Бельги), Бин (Япон), Дан Ма (Дани), Хэ Лан (Голланд), Ау (Австри) зэрэг есөн гүрний ГХЯ-нд илгээжээ. Ноот бичигт: **«дурьдсан улсын Засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилцож, ... харилцан гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлж, улсын найрамдлыг зузаатгамуу»**¹ гэсэн саналыг дэвшүүлсэн байна. Энэ ноот Монгол

*Д.Уламбаяр - ХИС-ийн Олон улс судлалын сургалт-судлагааны төвийн захирал доктор(Ph.D), профессор

Улсаас их гүрнүүдэд тухайлан Нэгдсэн Вант Улсад хандсан албан ёсны анхны баримт бичиг байв. Нэг сарын дараа Богд хаанаас хичээнгүйлэн Их Фа, Ин, Дэ, Билиш, Хэлан зэрэг таван улсын эзэн хааны амгаланг эрж, үүрд сайнаар найрамдахыг хүссэн албан бичгийг ч илгээжээ. Үүнийгээ 1913 онд Ерөнхий сайд, сайн ноён хан Т.Намнансүрэн Санкт-Петербургт айлчлахдаа болон 1914 онд ГЯЯ-наас Бээжин дэх Өрнөдийн орнуудын ЭСЯ-дад илгээсэн ноот бичигт дахин нотолж байжээ.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараахан Ардын Засгийн газрын Ерөнхий сайд бөгөөд Гадаад Хэргийн тэргүүн сайд Д.Бодоо Хаалган хотноо Гадаад Монголыг тухайлан хариуцсан АНУ-ын суурин консул С.Сокобиныг нийслэл Өргөөд хүлээн авч уулзсаны дараа 9 дүгээр сарын 14-нд Ардын Засгийн газрын ГХЯ-наас **Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичиг** гаргасан нь нэгэн адил Өрнөдийн орнууд, Нэгдсэн Вант Улсад аанай л хандсан хэрэг байв. Түүнд: «...Монголын хүн иргэнийг тус тусдаа энх төвшний улиралд хандуулахыг гүнээ эрмэлзэн бүхий дээр, бас ч гадаад олон улстай гэрээ байгуулан худалдаа арилжааг нэгэн адилаар нэвтрүүлэхийг эрмэлзэн байгаа явдлыг хамтад илэрхийлэн гаргав»² гэж дурдсан байна.

Ялтын нууц хэлэлцээр, Их Британийн оролцоо

Дэлхийн II дайны төгсгөлийн шатанд Алс Дорнод дахь Японы эсрэг дайны ажиллагаанд ЗХУ-ыг оролцуулах асуудалтай холбогдон дайны дараах БНМАУ-ын олон улсын эрхзүйн статусын асуудал яригдаж эхэлснээр уг асуудалд АНУ тодорхой үүрэгтэй оролцох болсон байна.

Анх энэ асуудлыг 1943 оны 11 дүгээр сард Каирт болсон их гүрнүүдийн удирдагчдын уулзалт дээр сөхөж тавьж байсан ажээ. Энэ хурлыг А+В+С (America, Britain, China) хэмээн нууцлан нэрлэж байжээ.

АНУ Lend lease хуулийн шугамаар Японы эсрэг тэмцэж байсан Гоминьданы удирдагч Чан Кайшийн дэглэмд олон сая ам. долларын тусламж үзүүлж байсан боловч Чан Кайши япончуудын эсрэг тэмцэхээсээ илүүтэй Мао Цзедун тэргүүтэй ХКН-тай мөчөөрхөн тэмцэж, Америкчуудад дорвитой дэмжлэг үзүүлээгүй байна. АНУ Номхон далайн сав нутагт цэрэг-дайны ажиллагааг идэвхтэй явуулах боломжтой, харин эх газрын Хятадын нутаг дэвсгэрт олон жил барьж байгуулсан бат бэх хориглолтын хамгаалалттай, 1.2

сая цэрэг бүхий Квантуны армийн эсрэг дангаараа хуурай замаар дайны ажиллагаа явуулах цэрэг-стратег, оператив-тактикийн боломж хомс байжээ. Тэгээд ч энэ дайны ажиллагааны цэрэг-хүн хүч, техникийн талаасаа дэндүү өндөр өртөгтэй байв. Америкийн стратегичдын үзэж байснаар дайн 1946 оны сүүл хүртэл үргэлжлэх магадлалтай байв.

Нөгөө талд АНУ, Британи хоёр Европт II фронт нээснийхээ хариуд Японы эсрэг дайнд ЗХУ-ыг татан оролцуулах бодолтой байв. Цэргийн дээд удирдлага Ф.Рузвельтэд ингэж зөвлөж байсан, тийм ч учраас Ф.Рузвельт И.Сталинд ихээхэн найдвар тавьж эхэлжээ. Нөгөө талд Холбоотнууд II фронт нээснээр Европт дайныг дуусгах хугацааг урагшлуулж, ЗХУ-ыг Японы эсрэг дайнд оролцуулах урьчилсан нөхцлийг бүрдүүлэх ёстой байжээ.

Бүр 1943 оны 10 дугаар сарын 30-нд Москвад амжилттай дууссан Холбоотон гурван гүрний дипломат албаны тэргүүн нарын уулзалтын төгсгөлийн хүлээн авалтын үед И.В.Сталин АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Корделл Хэлл, элчин сайд А.Харриман нарт ЗХУ Японы эсрэг дайнд тодорхой болзолтойгоор орох санаагаа тухайлан анх ойлгуулсан тухай Сталины хувийн орчуулагчаар ажиллаж байсан Валентин Михайлович Бережков дуртгалдаа бичжээ.

Зөвлөлтийн удирдагч И.В.Сталин Москва дахь АНУ-ын элчин Харримантай Ялтын бага хурлын бэлтгэл ажлын үеэр 1944 оны 10 дугаар сарын 15-нд уулзахдаа БНМАУ-ын status quo-г хадгална гэдэг нь Гадаад Монголын тусгаар тогтносон байдлыг хэвээр үргэлжлүүлэхийг хэлж байгаа юм гэж мэдэгджээ.³

Зөвлөлтийн арми Дорнод Европыг чөлөөлж эхэлмэгц Ф.Рузвельт Европын байдал, Нэгдсэн үндэстний түгээмэл байгууллагын талаар даруй хэлэлцэх гурван гүрний уулзалт хийх санал дэвшүүлж, У.Черчилль, И.Сталин нар ч ийм уулзалт хийх сонирхолтой байгаагаа мэдэгдэхийн хамт И.Сталин тэрхүү уулзалтыг Крымын ойролцоо Ялтад хийх санал тавьжээ.

Вудро Вильсоны олон улсын харилцааны институтэд буй Зөвлөлтийн талын шинэ баримтал тэмдэглэснээр Европт II фронт нээгдснээс хойш 5 сарын дараа 1944 оны 11 дүгээр сарын 7-нд Октябрийн хувьгалын 27 жилийн ойн өдөр АНУ-ын түүхэнд Ерөнхийлөгчөөр анх удаа дөрөв дэх удаагаа сонгогдсон Ф.Рузвельтэд баярын цахилгаан илгээх үед Сталин ихэд бэлгэшээн Рузвельтэд томоохон бэлэг барих бодолтой байсан гэжээ.⁴

Ф.Рузвельт 1945 оны 1 дүгээр сарын сүүлчээр Ялта руу

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

мордож, замдаа У.Черчилльтэй Мальтад уулзахдаа Гадаад Монголын status quo-гийн тухайд санал солилцсон байна.

Холбоотон гурван гүрний тэргүүн нарын бага хурал 1945 оны 2 дугаар сарын 4-нд Ялта хотноо байрлах Ливади Паласт нээгдэж, 11-н хүртэл долоо хоног үргэлжилж, найман салбар хуралдаан болжээ. АНУ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Төрийн нарийн бичгийн дарга Э.Стеттиниус, Ерөнхийлөгчийн Тамгийн газрын дарга У.Лейхи, Москвад суугаа элчин А.Харриман, Ерөнхийлөгчийн зөвлөх Х.Хопкинс, Хуурай замын цэргийн Жанжин штабын дарга генерал Ж.Маршалл, орчуулагчаар Төрийн департаментын Дорнод Европын хэлтсийн дарга Ч.Болен (Bohlen) болон албаны бусад хүмүүс, Зөвлөлтийн талаас ГХА-ын комиссар В.М.Молотов, ГХАК-ын нэгдүгээр орлогч, олон улсын хуульч А.Я.Вышинский, ГХАК-ын орлогч И.М.Майский, Вашингтон, Лондонд суугаа элчин А.А.Громько, Фёдор Т. Гусев, орчуулагчаар В.Н.Павлов, Их Британий талаас Гадаад Хэргийн сайд А.Иден, ГХЯ-ны Байнгын орлогч сайд А.Кадоган (Кадоган 1933-36 онд Бээжинд элчин зөвлөх, элчин сайд байсан, Гадаад Монголын талаар сайн мэдлэг, мэдээлэлтэй хүн, 1946 онд БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудлыг хэлэлцэж байх үед Британий Байнгын төлөөлөгч байв Д.У), Москвад суугаа элчин А.К. Керр (1938-42 онд Хятадад элчин байсан, Монголыг сайн мэднэ Д.У) албаны бусад хүмүүс оржээ.

Бага хурлын дундуур зөвхөн Америк, Зөвлөлтийн удирдагчдын хооронд явагдсан нууц яриа хэлэлцээны агуулга нь Алс Дорнодын асуудал байв. 2 дугаар сарын 8-ны үдээс хойш И.Сталин, Ф.Рузвельт нар гурван талын салбар хуралдааны өмнө хагас цаг уулзаж, Алс Дорнодын тухайд тусгайлан анхлан ярилцжээ. Бага хурлын өмнө Америкийн цэргийн удирдлага Японы эсрэг дайнд ЗХУ-ыг татан оруулах нь амин чухал гэдэг саналаа Ф.Рузвельтэд дахин илтгэсэн байв. Японы эсрэг дайнд ЗХУ хэзээ орох тухайд тов тодорхой цаг хугацаа америкуудын анхаарлыг гойд татаж байсан гэж зөвлөлтийн талын баримтад тэмдэглэсэн байна.

Ялтын бага хурлын үеэр 1945 оны 2 дугаар сарын 8-нд И. Сталин Ф.Рузвельтээс «Гадаад Монголын status quo-г хадгалах асуудлыг хэрхэн үзэж байна вэ?» гэж асуужээ. АНУ-ын Ерөнхийлөгч уг асуултад «Чан Кайшигай зөвлөлдөж амжаагүй, гэвч Гадаад Монголын status quo-г хэвээр хадгалах нь зүйтэй гэж бодож байна»⁵ гэсэн хариулт өгчээ.

И.Сталин ЗХУ нь Японы эсрэг дайнд тодорхой болзолтойгоор орохгүй бол зөвлөлтийн ард түмэн, Дээд Зөвлөлд түүний утга учрыг

тайлбарлаж чадахгүй гэдгээ Ф.Рузвельтэд ойлгуулсан байна.

Улмаар И.Сталин өөрийн дэвшүүлсэн нөхцөлийг гурван гүрэн бичгээр хүлээн зөвшөөрсөн тохиролцоо хийхийг санал болгосныг Ф.Рузвельт зөвшөөрчээ. А.Харриманы тэмдэглэснээр 2 дугаар сарын 10-нд Алс Дорнодын асуудлаар гурван товч уулзалт болж, В.Молотов энэ өдрийн үдээс хойш **«Японы эсрэг дайнд Орос Улс орохтой холбогдсон маршал Сталины улс төрийн нөхцөл»** гэсэн хэлэлцээрийн төслийг (меморандум для маршала Сталина)⁶ А.Харриманд өгчээ.⁷

А.Харриман энэхүү төсөлд гурван засвар оруулж, Ф.Рузвельтэд танилцуулан В.Молотовт буцааж өгчээ. 2 дугаар сарын 10-ны үдээс хойших салбар хуралдаан завсарламагц И.Сталин А.Харриман дээр очиж Дайренийг олон улсын боомт болгохыг зөвшөөрнө, харин Порт-Артур бол цэргийн бааз учраас түрээслэн авахаас өөр аргагүй хэмээн хэлжээ. А.Харриман Ерөнхийлөгчийн зөвшөөрөл хэрэгтэй гэхэд И.Сталин Ф.Рузвельтэд хандан ярилцахад тэрбээр зөвшөөрчээ. Хариуд нь И.Сталин төмөр зам Зөвлөлт, Хятадын хамтарсан зөвлөлд байхыг зөвшөөрч, Гадаад Монголын статус квогийн талаар Чан Кайшийн зөвшөөрлийг авах хэрэгтэй гэж нэмж хэлжээ. А.Харриман И.Сталинаас төсөлд бичгээр ямар нэгэн өөрчлөлт засвар хийх эсэхийг асуухад тэрээр “хийнэ” гэсэн байна. И.Сталин Гадаад Монголын талаар Чан Кайшийн зөвшөөрлийг авна гэдэг өгүүлбэрээ оруулсан төслөө тэр шөнөдөө хийж, А.Харриманд өглөө хүргүүлжээ. Харин төсөлд Америкийн талын оруулсан хоёр засварын араас “*ЗХУ-ын онцгой эрх ашгийг хамгаална*” (*the pre-eminent interests of the Soviet Union shall be safeguarded*) гэсэн тайлбар шинээр нэмэж оруулсан байна. Урьдчилж ярилцаагүй оруулсан дээрх өгүүлбэрийг А.Харриман Ф.Рузвельтэд танилцуулахад тэрээр онцын ач холбогдол өгөөгүй ажээ. Иймд А.Харриман цэргийнхнээс төслийн талаар санал авах нь зүйтэй гэж үзээд адмирал У.Лейхи, генерал Ж.Маршалл, адмирал Э.Кинг нарт тус бүрт нь үзүүлэн анхааралтай уншуулж саналыг нь асуужээ. Бүгд улс төрийн үр дагаварын талаар ямар нэгэн зүйл дурдалгүй, ЗХУ Японы эсрэг дайнд удахгүй орно гэдэгт л сэтгэл ханамжтай байжээ. 2 дугаар сарын 10-ны гурван их гүрний салбар хуралдаанд И.Сталин “... ЗХУ Японы эсрэг дайнд Германыг бууж өгснөөс хойш хоёроос гурван сарын дараа тодорхой болзолтойгоор орно...” гэж товчхон мэдэгджээ. Ф.Рузвельт хариуд нь “...өөрөөс нь авсан зүйлийг л зөвхөн буцаан авах манай холбоотны санал нь байж болох зүйл...” гэжээ. И.Сталин “...Японы булаан авсан зүйлсийг л зөвхөн эргүүлэн

авч байна. Японоос дайны төлбөр шаардахгүй...” гэсэн байна.⁸

Харин Монголын статус кво-г хадгалах тухай маршал Сталины тавьсан нэгдүгээр болзолд Америкийн тал засвар оруулах юмуу, эсвэл нэмэлт тайлбар хийх шаардлага тавиагүй тэр хэвээр нь үлдээсэн нь онцгой чухал байв. Гэхдээ энэ талаар И.Сталины зөвлөснөөр Чан Кайшийн зөвшөөрөл авах үүргийг Ф.Рузвельт хүлээснээс харахад Рузвельт Гадаад Монголын (БНМАУ) статус кво гэдгийг Харриманд Сталины тодорхой хэлж ойлгуулсныг өөрт нь уламжилсан тэр хүрээнд хангалттай ойлгосон нь тодорхой байна.

Тийнхүү «Маршал Сталины улс төрийн болзол» хэлэлцээний явцад хэлэлцээр болж өөрчлөгдөн, эцсийн хувилбараар «**Agreement Regarding Entry of the Soviet Union into the War against Japan, Top Secret Agreement**» нэртэй болсон ажээ.

1945 оны 2 дугаар сарын 11-ний үдээс өмнө гурван гүрний Гадаад хэргийн сайд нар Ялтын бага хурлаас гаргасан 14 зүйл бүхий эцсийн бүрэн Протоколд гарын үсэг зуржээ. Протоколыг харахад нэгдсэн үндэстний дэлхийн байгууллага байгуулах, чөлөөлөгдсөн Европын Тунхаглал, Герман дахь Холбоотнуудын эзэмшлийн бүсийн асуудал, дайны төлбөр, дайны гол гэмт хэрэгтнүүдийг шүүх, Европын улсуудын хил хязгаар зэрэг өргөн хүрээтэй асуудал хэлэлцэгджээ.

Ф.Рузвельт 2 дугаар сарын 11-ний үдээс хойш Ялтаас буцах тул гурван их гүрний удирдагчид Ливади Паласт 2 дугаар сарын 11-ний өдрийн зоогийн үеэр «**маш нууц ангилал**»-тай «**Японы эсрэг дайнд ЗХУ орохтой холбогдсон хэлэлцээр**»-т гарын үсэг зурцаажээ. Хэлэлцээрийн Америкийн талын ганц хувийг Ф.Рузвельт адмирал У.Лейхид хадгалуулжээ. Ялтад байгуулсан уг хэлэлцээр холбоотон гурван их гүрний бага хурлын албан ёсны хэлэлцэх хэргийн төлөвлөгөө, тэмдэглэлд ороогүй, сайхь асуудал их гурвын уулзалт, Гадаад Хэргийн сайд нарын бүгд хуралдаан дээр яригдаагүй, АНУ-ын бусад төлөөлөгчид ч мэдээгүй ажээ. И.Сталин дээд зэргийн нууцлал шаардсан нь Японтой төвийг сахих гэрээтэй, цэргийн хэргийн үүднээс мөн гэнэтийн цохилт хийдэг Японоос болгоомжилсон, тиймээс ч хэлэлцээрийн агуулгыг жилийн дараа нийтэд ил гарган зарлахаар тохиролцжээ. Яриа хэлэлцээ зөвхөн И.Сталин, В.Молотов, Ф.Рузвельт, А.Харриман нарын хооронд л явагдаж, У.Черчилль төдийгүй АНУ-ын Төрийн департамент, Төрийн нарийн бичгийн дарга Э. Стеттиниус ч оролцоогүй байна. У.Черчилльд энэхүү хэлэлцээр байгуулах тухай жичид нь танилцуулж гарын үсэг зуруулах зөвшөөрөл авч байснаас биш түүнтэй И.Сталин,

Ф.Рузвельт Гадаад Монголын статус-квог хадгалах талаар нүүр тулж ярилцаагүй байна.

Зөвлөлтийн талын баримтад тэмдэглэснээр 2 дугаар сарын 10-ны үдээс хойш Сталин, Молотов, Рузвельт, Харриман нар дөрвүүлхэнээ тусдаа уулзаж, хэлэлцээрийн бүтэц, агуулгын талаар нарийвчлан хэлэлцэж, энэ талаар Хятадын Засгийн газрын зөвшөөрлийг зайлшгүй авах шаардлагатай гэдэг дээр тохиролцоонд хүрч, орчуулагчаар В.Н.Павлов(1915-93)ажилласан байна. Маргааш нь Их Британий төлөөлөгчдөл танилцуулахад тэд татгалзаагүй, тэгээд 2 дугаар сарын 11-ний үдийн цайны завсарлагаар Иосиф Сталин, Франклин Рузвельт, Уинстон Черчилль нар хэлэлцээрт гарын үсэг зуржээ.⁹

У.Черчилль өөрийн дуртгалдаа: «...уг асуудал Америкийн тухайд тэргүүн зэргийн ач холбогдолтой байсан, харин бидний хувьд шууд хамааралтай байгаагүй. Шийд гармагц гарын үсгээ зурна уу гэсэн. Бид ёсоор болгосон...»¹⁰ гэжээ. Хэлэлцээрийн Английн талын нэг хувийг А.Иденд хадгалуулсан байна.¹¹

Харин Их Британий Гадаад хэргийн сайд А.Иден хэлэлцээрт гарын үсэг зуруулахын эсрэг байжээ. Тэрбээр И.Сталинд улс төрийн төлбөрт хэт ихийг өгч байна гэж үзээд, хариуд нь ямар нэгэн зүйлийг нэхэх байр суурьтай байжээ. Японд алдсан зүйлээ л эгүүлэн авч байгаа болохоос илүү зүйл нэхээгүй, тиймээс байхгүй зүйлээ алдана гэж байхгүй гэж Сталин үзжээ. У.Черчиллийн тухайд хэрэв хэлэлцээрт нэгдэн орохгүй бол дайны дараа Алс Дорнодын үйл хэргээс Их Британи гадна үлдэж магад хэмээн болгоомжлон гарын үсэг зуржээ. Тэрбээр Каир, Ялтын тохиролцооны дагуу Хятадын зөвхөн Японд алдсан газар нутгийг л Хятадад буцаан өгнө, тиймээс Хонгконг, Гадаад Монгол нь үүнд хамаарахгүй гэж үзэж байжээ.

Маш Нууц Хэлэлцээр

Японы эсрэг дайнд ЗХУ орохтой холбогдсон

Нууц Хэлэлцээр

Гурван их гүрэн ЗХУ, АНУ, Их Британий удирдагчид Герман буун өгч, Европт дайн дууссанаас хойш хоёроос гурван сарын дараа Холбоотнуудын талд ЗХУ дараах нөхцөлтэйгээр Японы эсрэг дайнд оролцохоор тохиролцов. Үүнд:

1. Гадаад Монголын (Бүгд Найрамдах Монгол Ард Улс) status quo-г хадгална;¹² (орос хэл дээрх уг эхэд «сохранения status quo Внешней Монголии (Монгольской Народной Республики)» харин “Гадаад Монгол дахь” гэж орчуулах нь буруу юм. Д.У).

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

Маш нууцын зэрэглэлтэй энэ хэлэлцээр гурван гүрний Ялтын дээд уулзалтын бага хурлын англи, орос хэл дээр хэвлэгдсэн албан ёсны баримт бичгүүдийн эмхтгэлд “Agreement Regarding Japan”, эсвэл “Agreement between the Three Great Powers on Questions of the Far East”, орос хэл дээр “Ялтинское соглашение трех великих держав по вопросам Дальнего Востока” нэртэйгээр албан ёсны, нээлттэй хэлэлцэгдсэн баримт бичгүүдийн хамт нэг багц шинжтэйгээр орсоор ирэв. Гэтэл уг хэлэлцээр бага хурлын хэлэлцээний гадуур, тусдаа, маш нууц зэрэглэлтэй байгуулагдсан байна.

Тегеран болон Ялтын бага хурлын баримт бичгүүдэд гурван гүрний тэргүүн нар англи үсгийн цагаан толгойн дарааллаар гарын үсгээ зурж байсан бол, top secret хэлэлцээрт эсрэгээр И. Сталин, Франклин Д.Рузвельт, Уинстон С.Черчилль гэсэн дарааллаар гарын үсгээ зурсан нь уг хэлэлцээр Сталины болзол болохын хувьд тэрбээр эхэлж зурах ёстой байсан ажээ.

Ялтын бага хурлын төгсгөлийн шатанд байгуулсан маш нууц хэлэлцээрт «Гадаад Монголын (Бүгд Найрамдах Монгол Ард Улс) status quo-г хадгална» гэсэн заалтыг ЗХУ Японы эсрэг дайнд орохтой холбогдсон улс төрийн болзлуудын нэгдүгээрт тусгаж оруулсан нь Сталины хувьд ЗХУ-ын Алс Дорнодын аюулгүй байдалтай холбоотой геополитикийн нэн чухал асуудал байсан бол БНМАУ-ын хувьд Хятадаас олон улсын эрхзүйн тухайд огт хамааралгүй болж, тусгаар тогтносон бүрэн эрхт улс болох замд нэн чухал, шийдвэрлэх ач холбогдолтой болсон байна. АНУ-ын хувьд нууц хэлэлцээрийн хамгийн чухал ач холбогдол нь Японы эсрэг дайнд ЗХУ орох хугацааг яв цав тодорхойлсон явдал байжээ. АНУ ардчилсан орон мөн болохын хувьд олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, өөрөөр хэлбэл Чан Кайшид нөлөөлөх л үлдсэн байна. ЗХУ 1945 оны 8 дугаар сарын 9-нд Японд дайн зарласан нь чухам Ялтын хэлэлцээрээр хүлээсэн амлалтын сүүлчийн өдөр байсан болно.

НҮБ-д элсэх БНМАУ-ын дипломат хүчин чармайлт ба Нэгдсэн Вант Улсын байр суурь, de facto хүлээн зөвшөөрсөн нь

Монгол Улс 1921 онд тусгаар тогтнолоо байлдан олж, 11 дүгээр сарын 5-нд Зөвлөлт Оростой найрамдлын гэрээ бичиг байгуулж, дипломат харилцаа тогтоон, 1924 онд анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах улсаа Тунхагласнаас хойш 25 жил болсон байв. Түүнчлэн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн (АЗ) Байнгын

хоёр гишүүн бөгөөд умард хөрш ЗХУ-тай найрамдал, хамтын ажиллагааны шинэ гэрээ байгуулж, Дундад улс хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоов. Энэ тухай 1946 оны 3 дугаар сарын 6-нд маршал Х.Чойбалсан Францын «Ссория» (“*Se soir*”-Сё свуар гэх франц үгийг тухайн үед Ссория гэж хөрвүүлсэн байна Д.У) сонинь Москва дахь сурвалжлагч Джоржи Суриядаугийн тавьсан дөрвөн асуултад бичгээр хариулахдаа дэлгэрэнгүй дурджээ.¹³ Мөн өдөр ЗСБНХУ-д суугаа Хятадын «Централь» сонинь сурвалжлагч Зо Чиняй (Жу Цинюй)-гийн асуултад бичгээр хариулт өгөхдөө ч нэгэн адил тэмдэглэсэн байна.

Тийнхүү БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд, маршал Х.Чойбалсангаас 1946 оны 6 дугаар сарын 21-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Трюгве Ли-д явуулсан бичигтээ: «БНМАУ-ын ард түмэн нь өөрийн их хөрш ЗХУ-д эд материалын тус нэмрийг үзүүлэн, Нэгдсэн үндэстний талд орж, фашист улсуудын эсрэг тэмцэлд оролцсоныг Аюулгүйн Зөвлөл ба түүнчлэн Ерөнхий Их хурлын анхааралд толилуулах нь зүйтэй хэмээн тус улсын Засгийн газраас үзнэ. БНМАУ нь 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Японд дайн зарлаад, энэхүү улсыг эсэргүүцсэн дайны явдалд оролцсон юм. Нэгдсэн Үндэстний нийтийн хэрэгт Монголын ард түмнээс үзүүлсэн энэхүү тус нэмрийн тухай Аюулгүйн Зөвлөл ба түүнчлэн Ерөнхий Их хурал мартажгүй бөгөөд БНМАУ-ыг Нэгдсэн Үндэстний (Байгууллагын Д.У) гишүүнд элсүүлэн авах тухай хүсэлтийг зөвшөөрөн авч үзэх болов уу хэмээн БНМАУ-ын Засгийн газар үнэхээр итгэж байна».¹⁴ гэсэн байв. Энэхүү өргөдөлд БНМАУ НҮБ-ын дүрмийн дагуу өөрт ногдох үүрэг, хариуцлагыг хүлээн авч, түүний бүх үндэслэлийг биелүүлэхэд бэлэн байна гэдгийг илэрхийлжээ.

НҮБ-ын АЗ-өөс томилогдсон шинээр гишүүн элсүүлэх хороо Монголын өргөдлийг 1946 оны 8 дугаар сарын 6-нд хэлэлцжээ. Нью-Йорк хотноо болсон комиссын хурал дээр Дундад улсын төлөөлөгч Цзво Тайчжи (Quo Tai-chi 1888-1952) БНМАУ-ын өргөдлийг нэг жилээр хойшлуулья, учир нь зөвхөн СССР-тэй дипломат харилцаатай, манай оронтой элчин солилцохоор тохирсон, бусад орнуудтай дипломат ба консулын харилцаагүй байгаа явдал нь дэлхий дахины байгууллагад гишүүн болох явдалд БНМАУ бэлэн болоогүй байгаагийн гэрч мөн, НҮБ-ын гишүүний үүргийг энэ улс биелүүлж чадна гэдэгт итгэлтэй байхын тулд сайн танилцах хэрэгтэй, бусад орнуудтай харилцаа холбоогүй байгааг зөвхөн газарзүйн алслагдснаар тайлбарлагдахгүй, БНМАУ-д тусгаар тогтнол олгосон

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

орны хувьд Хятад улс тохиромжтой цаг ирэхэд тус орны өргөдлийг баяртай дэмжих болно гэж аягиласан байна. БНМАУ-ын өргөдлийг хүлээн авахыг дэмжиж ЗХУ-ын төлөөлөгч А.Громыко хэлэхдээ: БНМАУ бие даасан ардчилсан залуу улс, 25 жил оршин тогтнож байгаа, тэнхлэгийн гүрнүүдийн эсрэг Нэгдсэн Үндэстнүүдийн тэмцэлд их хувь нэмэр оруулсан, Пирл-Харборын явдлаас өмнө Японы түрэмгийлэлд өртөж байсан, фашист германы эсрэг дайнд улаан армид эд материалын тусламж нэн даруй үзүүлсэн, өөрийн хөрөнгөөр танкийн бригад, нисэх онгоцны эскадриль байгуулан дайн дуустал хөрөнгөөрөө ажиллуулсан, 1945 оны 8 дугаар сард Японд дайн зарлаж, Алс Дорнодод дайны голомтыг дарахад шууд оролцсон, 195 сая төгрөг буюу 50 сая долларын хохирол хүлээсэн, Хятадын саналд гайхаж байна гэжээ. Польшийн төлөөлөгч (Oscar Lange) Хятадын төлөөлөгчийн тавьсан саналыг гайхаж байна, аливаа улсыг бусад улсын зүгээс албан ёсоор зөвшөөрөх гэсэн явдал бол тус улсыг НҮБ-д элсүүлэхэд холбогдолгүй гэж хэлсэн байна. Хятад, АНУ, Англи болон бусад зургаан улсын төлөөлөгчид БНМАУ-ын тухай шинэ мэдээ авахаас нааш тодорхой санал гаргахаас татгалзаж, ийнхүү Нью-Йоркт Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид хүрэлцэн ирэхээс нааш БНМАУ-ын өргөдлийг цаашид хэлэлцэхийг тус комиссоос хойшлуулжээ. Ингэж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газраас Монголын төлөөлөгчдийг урьсан цахилгаан утас ирсэн учиртай ажээ. Урилгын хамт НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс БНМАУ-ын Засгийн газарт тус улсын гадаад харилцаатай холбоотой үндсэн дөрвөн асуулт тавьсан байв.¹⁵

Чингээд томоохон бэлтгэл ажил өрнөжээ. Үүнд: нэгд, Олон улсын хоорондын асуудлын талаар холбогдох материалуудыг НТХ-ны Дүгэрсүрэн, Содномдондог, хоёрт, Монголын түүхийн талаар Цэрэндорж, Чойжил, гуравт, Зөвлөлт, Монголын харилцааны асуудлаар Цэдэн, дөрөвт, БНМАУ эх орны дайны үед сэдвээр Дүгэрсүрэн, тавд, Монгол ба Японы харилцааны талаар Н.Лхамсүрэн, Б.Жаргалсайхан, зургаад, Монгол ба Хятадын харилцааны тухай асуудлуудыг дурдсан хоёр бэлтгэх болсон байна. Түүнчлэн Атлантын болон Тегеран, Ялта, Потсдамын тунхаглал, Думбартолл Окс, Сан Францискогийн хурлын материал, НҮБ-ын Дүрэм, хуралдааны материал, Рузвельт, Черчилль, Чан Кайши нарын хэлсэн үг, Парисын бага хурлын материал, Ялтын бага хурлын үеэр гаргасан Монголын тухай тунхаглал, Латтимор, Уоллес нарын статьянууд, 1921, 1946 оны Монгол-Зөвлөлтийн гэрээ зэрэг маш олон материалууд орсон байна. Мөн төлөөлөгчдийн нэрийн хуудас, туг далбаа, үнэмлэх

монгол, орос, англи хэлээр бэлтгэх зэрэг байв.¹⁶

Н.Лхамсүрэнгийн дурсамжаар энэхүү хуралдаанд оролцох БНМАУ-ын Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчдийн тэргүүнээр Монгол дахь Зөвлөлтийн элчин сайд И.А.Ивановын «саналаар» маршал Х.Чойбалсан МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалыг томилжээ. Төлөөлөгчдийн тэргүүний хувьд түүнийг Ерөнхий сайдын 1 дүгээр орлогч болгосон байна. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ГЯЯ-ны орлогч сайд Н.Лхамсүрэн, мөн яамны референт Б.Жаргалсайхан зэрэг хүмүүс оржээ. Төлөөлөгчид хуралдаанд оролцох бэлтгэлээ Москвад очиж дуусгаад Нью-Йорк орох замдаа Парист Зөвлөлтийн ЭСЯ-нд саатаж В.М.Молотовтой ярилцжээ. Молотов, Цэдэнбал хоёрын ярилцлагын гол сэдэв нь тэр жилээ дөнгөж тусгаар тогтноод байсан, Английн мандатын нутаг дэвсгэр, Трансиорданы (Иордан Д.У) вант улсын тухай байжээ.¹⁷

Ю.Цэдэнбал тэргүүтэй Монголын Засгийн газрын төлөөлөгчид Нью-Йоркт очмогцоо АЗ-өөс тавьсан үндсэн дөрвөн асуултын хариуг тус Зөвлөлд өгчээ.

1946 оны 8 дугаар сарын 28-нд АЗ-ийн хурал НҮБ-ын гишүүн элсүүлэх комиссоос Албани, БНМАУ, Афганистан, Трансиордан, Ирланд, Португаль, Исланд, Швед зэрэг 8 улсын өргөдлийн тухай оруулсан илтгэлийг хэлэлцэж эхлэв.

Шинэ гишүүн элсүүлэх тухай ерөнхий шүүмжлэл эхлэхэд Америкийн төлөөлөгч Жонсон (үүрэг гүйцэтгэгч (Herschel V. Johnson 1894-1966) Д.У) НҮБ-д шинээр гишүүн элсүүлэх явдал дээр түгээмэл (универсиализм) зарчмыг хэрэглэхийн чухал учрыг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Тэрбээр энэ зарчмыг тайлбарлахдаа «Нэгдсэн Үндэстнүүд амжилт олохыг хүсэх бол нэг ч улс түүний гадна гарцаагүй хэрэгтэй хугацаанаас удаанаар байх ёсгүй. Иймд миний Засгийн газар НҮБ-ын Дүрмийн 4 дүгээр зүйлд зохицуулан бололцооны хэрээр НҮБ-ыг шинэ гишүүдээр өргөтгөх алсыг харсан шийдвэр гаргах саналыг АЗ-д тавьж байна. Үүнээс үндэслэн Зөвлөл өргөдөл өгсөн бүх улсыг НҮБ-д нэгэн зэрэг элсүүлэхийг зөвлөсөн шийдвэр гаргах санал оруулья» гэсэн байна. Америкийн саналыг АЗ-ийн 11 гишүүн улсаас (энэ үед АЗ-ийн гишүүн 15 биш 11 байсан болно Д.У) Бразил, Мексик, Египетийн төлөөлөгчид зөвшөөрөн дэмжиж, Австралийн төлөөлөгч үл зөвшөөрөв. Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Трюгве Ли (Trygve H.Lie) нэгэн адил дэмжжээ.

Гэвч Зөвлөлтийн төлөөлөгч А.А.Громыко ангийн шалгуур зарчим баримтлан Америкийн төлөөлөгчийн саналын «алдаатай

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

болохыг илчлээд» өргөдөл өгсөн улс "...орнуудыг эд хогшилд ханддаг шиг хандлагаар авч үзэж болохгүй. Бүх орнуудыг түгээмлээр нэг маягаар үзэж, тийм журмаар НҮБ-д оруулж болохгүй" харин тус бүрт нь холбогдох материал, нөхцлүүдийн үүднээс өргөдөл тус бүрт нягтлан авч үзэх хэрэгтэй гэж хэлэв. Иймээс Нэгдсэн Вант Улсын төлөөлөгч Кадоганаас (Alexander Cadogan Ялтын хэлэлцээрт Гадаад Хэргийн Байнгын орлогч сайдын хувиар оролцсон Д.У) «өргөдөл өгсөн хоёр улс дээр эргэлзээ байна» гэж БНМАУ, Албани хоёрыг битүүгээр хэлжээ. Голландын төлөөлөгч Ван Клеффенсийн (E.N. van Kleffens) үг ч Британийхтай адил байв.

Зөвлөлтийн төлөөлөгчийн байр сууриас болоод Америкийн түгээмэл буюу өргөдөл өгсөн бүх улсыг нэгэн зэрэг элсүүлэх санал унахад Америкийн төлөөлөгч байр сууриа өөрчилж, Албани болон Монголын өргөдлийн тухай АЗ-өөс шийдвэр гаргахгүйгээр эдгээр өргөдлийг хэлэлцэх явдлыг хойшлуулах хэрэгтэй гэж хэлэв. Английн төлөөлөгч мөн адил байр суурь илэрхийлжээ. Өргөдлийг нэг бүрчлэн хэлэлцэх явцад Чан Кайшийн төлөөлөгч Ся (Байнгын төлөөлөгчийн орлогч, T.F.Tsiang 1895-1965): АЗ-ийн тавьсан асуултад хариулсан БНМАУ-ын хариу нь Дундад улсад хангалттай учир өргөдлийг дэмжихэд бэлэн гэж хэлчихээд утгагүй зүйл ярьсан нь Монголчуудыг дарлаж байсан Манж-Хятадын дарлалын хоёр зуун жилийн түүхийг алгасан харайж «Монголчууд Хятадыг байлдан эзэлж, бид түрэмгийлэлд хэлмэгдэж байсан», «Дундад улс БНМАУ-д тусгаар тогтнолыг олгосон орон» гэх зэргээр хэлж байжээ. АНУ Зөвлөлтийн байр сууринаас шалтгаалан Монголын тухайд татгалзах хандлагатай болоход Гоминьданы Хятад дэмжсэн байр суурьтай байсан нь уялдан зохицуулсан бодлогын илрэл байв.

Нэгдсэн Вант Улсын төлөөлөгчийн гаргаж ирсэн ганц зүйл нь БНМАУ зөвхөн хоёр улстай дипломат харилцаатай учраас олон улсын харилцааны туршлага хүрэлцэхгүй гэжээ. АНУ БНМАУ-ыг оролцуулан өргөдөл гаргасан бүх улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлэн авах саналаа тов тодорхой илэрхийлсэн юм.

ЗХУ БНМАУ-ыг НҮБ-д үнэхээр гишүүнээр элсүүлэхийг хүсч байсан бол Америкийн түгээмэл буюу нийтээр нь эслүүлэх санал, зарчим дээр зөвшилцөж болох байсан ба хэрэв Америкийн санал унахад хүрвэл Зөвлөлтийн дэмжиж байсан Монголын эсрэг санал өгөх нь ойлгомжтой байсан хэрэг. АЗ-ийн Байнгын таван гишүүдийн нэг нь санал өгөөд татгалзахад өргөдлийг хүлээн авахгүй журамтайг Зөвлөлтийн төлөөлөгч ойлгож байсан нь илэрхий. Тиймээс БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр элсүүлснээс Трансиорданыг

элсүүлэхгүй байх нь ЗХУ-д илүү дээр хийгээд стратегийн талаасаа ашигтай байсан бололтой. ЗХУ өөрөө 1949, 1950-иад онд өргөдөл гаргасан улсуудыг түгээмэл зарчмын үндсэн дээр ялгаварлахгүйгээр элсүүлэх санал дэвшүүлсэн боловч тэр нь дэндүү хожимдсон хэрэг болсон юм.¹⁸

Харин НҮБ-ын АЗ-ийн Байнгын гишүүн Франц улс л элдэв тайлбар, шалтаг, шалтгаан, ил далд эрх ашиг, болзол тоочилгүй, бусад гүрний нөлөөнд авталгүй, бие дааж БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр элсэхэд саналаа өгчээ. Үүгээрээ Франц улс БНМАУ-ын тусгаар тогтнолыг аль 1946 онд “de facto” хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болохоор байгаа юм.¹⁹

БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр элсүүлэх АЗ-ийн гишүүн 11 улсаас санал хураахад ЗХУ, Франц, Дундад улс, Польш, Мексик, Бразил зэрэг 6 улс «төлөө» санал өгч, АНУ, Англи, Голланд гурав татгалзаж, Австрали, Египет хоёр түдгэлзэв. Ийнхүү АЗ-ийн Байнгын хоёр гишүүн НҮБ-д авахыг татгалзсан тул Монгол Улсын өргөдлийг хүлээн авалгүй хойшлуулжээ.

Монголын төлөөлөгчид Нью-Йоркоос буцаж ирсний дараа Ю.Цэдэнбал Улаанбаатар хотын намын идэвхтний хурал дээр «БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд аваагүйн шалтгаан» гэсэн томоохон илтгэл тавьж, түүнд Өрнөдийн орнуудыг шүүмжлэн буруутгаж, ЗХУ-ыг магтан сайшаасан байна.

Монгол Улс НҮБ-д элсэхийн төлөө 1946 оноос эхлэн 1961 он хүртэл 15 жилийн туршид 4 удаа өргөдөл гаргаж, нийтдээ 13 удаа хэлэлцэгдэж, Х.Чойбалсангийн гарын үсэгтэй хоёрдахь өргөдлийг 1948 оны 10 дугаар сарын 25-нд илгээжээ. Үүнийг 1949 оны 6 дугаар сарын 16; 1951 оны 12 дугаар сарын 19; 1952 оны 2 дугаар сарын 1; 1952 оны 9 дүгээр сарын 5; 1954 оны 11 дүгээр сар; 1955 оны намар тус тус хэлэлцэж байжээ.²⁰

Гуравдахь удаад НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Даг К. Хаммаршельдын (Dag Carl Hammarshild) нэр дээр СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбалын гарын үсэгтэй өргөдлийг 1956 оны 9 дүгээр сарын 14-нд гардуулсныг мөн оны 12 дугаар сарын 12-нд хэлэлцүүлсэн байна. Энэ тухай «БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх тухай худал»-нэртэй түүхчилсэн томоохон өгүүдэл «Үнэн» сонины 9 дүгээр сарын 4-нд нийтлэгджээ.

Сүүлчийн удаа 1957 оны 9 дүгээр сарын 1-нд ГЯЯ-ны сайл С.Аварзэдийн гарын үсэгтэй өргөдлийг 1957 оны 9 дүгээр сарын 9-нд хэлэлцэж байжээ. Гол нь Чан Кайшийн Хятад, АНУ, түүнчлэн ЗХУ-ын ангич байр сууринаас шалтгаалан хойшлогдсоор байжээ.

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

Энэ хугацаанд Франц улс БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхийн төлөө саналаа өгч байсан байх бөгөөд 3 удаа түдгэлзэж байжээ. Олон улсын эрхзүйн практикт “түдгэлзэх” нь эсэргүүцэний шинж биш гэж үзэх ёсон байсаар иржээ. Франц улс БНМАУ-ыг аль 1946 онд “de facto” хүлээн зөвшөөрсөн тухай ярихдаа үүний өмнө холбоотон гурван гүрний Ялтын нууц хэлэлцээрээр АНУ, Их Британи хоёр БНМАУ-ын (Гадаад Монгол) “status quo”-г (одоогийн бодит байдал) хүлээн зөвшөөрсөн байсныг тэмдэглэх хэрэгтэй. Иймээс Их Британи БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр элсэхэд «олон улсын харилцааны туршлага хангалтгүй» гэж эсрэг санал өгснөөс биш, БНМАУ-ын оршин байгаа бодит байдлыг үгүйсгээгүй юм. АНУ-ын хувьд төлөөлөгч Жонсон хэлэхдээ: «Хэрэв одоо өргөдлөө өгсөн орнуудын тоонд олон улсын ач холбогдлын үүднээс улс биш буюу Дүрмээр хүлээх үүргүүдээ биелүүлэхэд шаардагдах засаг захиргаа эсхүл материаллаг зүйлсгүй тийм орон байсан бол бид ийм санал оруулахгүй байхсан билээ. Үүнээс үндэслэн одоо өргөдлөө өгсөн улсуудыг нийтэл нь элсүүлэн авахыг Ерөнхий Ассамблейд зөвлөх шийдвэр гаргахыг Зөвлөлөөс хүснэ» гэж мэдэгдсэн нь Монгол Улсын тухайд «status quo»-г хүлээн зөвшөөрснөө дахин нотолсон төдийгүй de facto хүлээн зөвшөөрөх бодолтой байсан хэрэг байв. Тэгэхлээр 1946 онд БНМАУ-ыг ЗХУ, АНУ, Их Британи, Франц, Дундал улс хүлээн зөвшөөрсөн байв.

1947 оны 7 дугаар сарын 18-нд АЗ-д Монголын өргөдлийг хэлэлцэхэд Байтаг Богдын хэрэг явдлаас шалтгаалан Гоминьданы Хятад, АНУ, Нэгдсэн Вант Улс татгалзсан байна. 1948 оны 4 дүгээр сарын 7-ны АЗ-ийн Байнгын гишүүдийн зөвлөлгөөн дээр СССР-ийн төлөөлөгч мэдэгдэхдээ бусад гүрнүүд Албани, БНМАУ-ыг элсүүлэхийг зөвшөөрвөл Трансиорданийг элсүүлэхэд татгалзахгүй гэж наймаалцах гэсэн боловч Гоминьдан, АНУ, Британи, Франц саналыг хүлээж аваагүй ажээ. 1949 оны 6 дугаар сарын 16-нд АЗ-д БНМАУ-ыг оролцуулан 12 улсыг нэгэн зэрэг элсүүлэх СССР-ийн оруулсан саналыг хэлэлцэхэд Гоминьдан, Канад татгалзаж, түгээмэл зарчмыг санал болгож байсны хувьд АНУ, Британи, Франц гурав анх удаа түдгэлзсэн байна. 1952 онд Британи, Франц түдгэлзсэн, 1955 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн X чуулган дээр БНМАУ-ыг оролцуулан өргөдөл өгсөн 18 улсыг бүгдийг нь нэгэн зэрэг НҮБ-д элсүүлэх тухай тогтоолын төслийг 52 улс түүний дотор Нэгдсэн Вант Улс баталж, АНУ түдгэлзсэн байна. 1955 онд АЗ-д санал хураахад Нэгдсэн Вант Улс дэмжиж, АНУ мөн л түдгэлзжээ. 1956 онд АНУ, Британи, Франц түдгэлзсэн, 1957 оны 9 дүгээр сарын 9-нд АЗ-д

санал хураахад Британи, Франц хоёр түдгэлзсэн байна.

Шинээр тусгаар тогтносон НҮБ-ийн гишүүн бүлэг орнуудаас Гоминьданы Хятадын НҮБ-д төлөөлөх эрхийг ноцтой хөндөж байсан үед 1961 оны 10 дугаар сарын 25-нд НҮБ-д шинээр гишүүн элсүүлэх талаар АЗ-ийн хуралдаан болж, БНМАУ, Мавританийн өргөдлийг авч хэлэлцжээ. Зөвлөлтийн төлөөлөгч В.А.Зорин НҮБ-д БНМАУ-ыг гишүүнээр авах талаар ЗХУ-аас оруулсан тогтоолын төслийг АЗ-өөс батлахыг уриалжээ. Дараа нь АЗ-ийн Байнгын бус гишүүн Либерти улсын төлөөлөгч Борнес (Nathan Barnes) Монгол Улсыг НҮБ-д гишүүнээр элсэх явдлыг дэмжихээ илэрхийлэв.

НҮБ-д хууль бусаар суугаа Тайваний Хятадын Бүгд Найрамдах Улсын Байнгын төлөөлөгч Цзян* (төлөөлөгчийн орлогч, доктор Ү.С.Hsueh 1962 оноос Байнгын төлөөлөгч, 1964 оноос Канадад. 1970-1972 онд Испанид элчин сайд байв) хэлэхдээ: Монгол Улс XIII зууны эхэн үеэс Хятадын салшгүй хэсэг байсан гэх зэргээр иш үндэсгүй үг хэлж төгсгөлд нь Мавритани улсыг НҮБ-д гишүүнээр элсэх явдлыг дэмжихийн тулд Монголын талаарх санал хураахад оролцохгүй гэжээ. Тухайн үед Хятадын Тайванийн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд төлөөлөх эрх нь хууль, эрхзүйн хувьд ноцтой хөндөгдөөд байсан үед арга буюу, түүнчлэн Мавританийг дэмжихийн тулд Монголын төлөө санал хураалтад оролцоогүй юм.

АНУ-ын төлөөлөгч Иост (H.Jost, орлогч, Minister, Deputy Permanent Representative) Монгол Улсын НҮБ-д гишүүнээр элсэхэд «замыг нь засахын тулд» санал хураахад түдгэлзэнэ гэв. Тийнхүү АНУ, Тайвань хоёр НҮБ-д БНМАУ-ыг элсүүлэх асуудал дээр харилцан тохиролцсон нь Байнгын төлөөлөгчийн түвшинд биш, харин Байнгын төлөөлөгчийн орлогч Цзян үг хэлж, санал хураалтад оролцоогүй бол, АНУ-ын Байнгын төлөөлөгчийн орлогч Иост үг хэлж, санал хураалтад түдгэлзэж дипломат заншилд «дэмжихгүй ч эсэргүүцэхгүй» гэсэн байр сууриар харагдсан юм. Энэ үед АНУ-ын Байнгын төлөөлөгчөөр Стевенсон (Adlai E.Stevenson 1900-65) ажиллаж байжээ.

Францын төлөөлөгч Берард (Armand Berard) хэлэхдээ БНМАУ-ын кандидатурын эсрэг хэзээ ч зогсож байгаагүй юм. Зарим санал хураалтад түдгэлзэж, заримд нь элсүүлэхийн төлөө саналаа өгч байсан юм. Францын төлөөлөгч БНМАУ-ыг элсүүлэхийн төлөө саналаа өгнө. Энэ бол БНМАУ-ын тусгаар тогтнох зориг хүслийг итгэмжилж байгаа бөгөөд тус орны байгууллагууд ардчилсан чиглэлээр хөгжинө гэж найдаж байгаагийн шинж тэмдэг юм гэжээ.

Нэгдсэн Вант Улсын төлөөлөгч сэр Патрик Деан (Sir Patrick

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

Dean) манай төлөөлөгч нарийвчлан судалж үзсэний эцэст Гадаад Монголыг НҮБ-д элсүүлэхийг дэмжих саналаа өгөхөөр шийдсэн юм. **Үнэндээ бидэнд Гадаад Монголыг тусгаар тогтносон гэж үнэмших баримт бага байгаа бөгөөд үгүй гэх баримт бас нэгэн адил бага байна. Улс төрийн дүгнэлтийг нь бид хүндэтгэдэг Энэтхэг зэрэг бусад орнууд Гадаад Монголыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон явдлыг харгалзсан ба би ч өнөөдөр бас үүнийг харгалзан үзэж байна гэжээ.**

Дараа нь Арабын Нэгдсэн улсын төлөөлөгч Лоутфу (Omar Loutfu) , Цейлоны (Шри Ланк Д.У) төлөөлөгч (Т.В. Subasinghe) нар дэмжихээ илэрхийлж дэлгэрэнгүй үг хэлжээ. Энэчлэн Эквадорын төлөөлөгч Бенитез (Leopoldo Benites Vinuesa), Чилийн төлөөлөгч Швайтзер (Daniel Schweitzer) болон Туркийн төлөөлөгч Түргүт (Turgut Menemencioglu) тус улсыг НҮБ-д элсэх явдлыг дэмжиж саналаа тайлбарлан ярив. Ийнхүү НҮБ-ын АЗ-ийн 11 гишүүд БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд элсүүлэх төсөлд хэрхэн санал өгөх нь тодорхой болсон байна.²¹

Санал хураасны дүнд АЗ-ийн гишүүдээс 9 нь зөвшөөрч, АНУ түдгэлзэн, Хятадын Тайвань санал хураахад оролцоогүй тул БНМАУ-ыг НҮБ-ын гишүүн болгох асуудал АЗ-д олонхийн саналаар шийдвэрлэгдсэнийг Зөвлөлийн даргаас зарлаж, тогтоолыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейд зөвлөмж болгов. 1961 оны 9 дүгээр сарын сүүлээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Даг К.Хаммаршельд Умард Родези буюу өнөөгийн Замбид нисэх онгоцны ослоор амь үрэгдэж, оронд нь НҮБ дэх Бирмийн Байнгын төлөөлөгч У Тан (Pantanaw U Thant) Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байжээ.

Мавританийн талаар АЗ-ийн гишүүд тус бүрийн байр суурийг илэрхийлсний дараа тус улсыг НҮБ-д элсүүлэх тогтоолын төсөлд санал хураахад Арабын Нэгдсэн Улс татгалзаж, ЗХУ түдгэлзэн бусад 9 гишүүн батлав.

1961 оны 10 дугаар сарын 27-нд Ерөнхий Ассамблейн XVI чуулганы 1043 дугаар хуралдаанд БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд элсүүлэхээр 23 улс төсөл оруулж хуралдаан БНМАУ-ыг НҮБ-д санал хураалгүйгээр элсүүлэх шийдвэр гаргасан байна. Ийнхүү НҮБ-д элсэх олон жилийн хүчин чармайлт амжилтад хүрч, Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн 101 дэх гишүүн болсноор тус улсын тусгаар тогтнол олон этгээдээс баталгаажиж, Монгол орон тусгаарлагдмал байдлаас гарах, дэлхий дахинаа тулгамдсан асуудлыг

шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах, дэлхийн олон оронтой хамтран ажиллах өргөн зам тус орны өмнө нээгдэж, капиталист орнуудаас тус орныг хүлээн зөвшөөрөх үе эхэлсэн билээ.

НҮБ бол дэлхий дахины тусгаар тогтносон улсуудын хамтын нийгэмлэг мөний хувьд тухайн улсыг НҮБ-д гишүүнээр элсүүлэх асуудал АЗ болон Ерөнхий Ассамблейн нэгдсэн чуулганаар хэлэлцэн шийдвэрлэх үед гишүүн улсууд «төлөө» санал өгсөн тохиодолд үүнийг олон улсын эрхзүй, дипломатын эрхзүйн заншилд тухайн улсыг «de facto» хүлээн зөвшөөрсөн гэж үздэг агаад мөн хамтаар хүлээн зөвшөөрөх үйл хэмээн нэрлэдэг.

Нэгдсэн Вант Улс 1928 онд Хятадын Бүгд Найрамдах Улстай тогтоосон дипломат харилцаагаа Хятадын коммунист хувьсгалын ялалтын дараа 1950 онд тасалж БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгосон түүхтэй. Тиймээс энэ үед Их Британид Тайваний зүгээс үзүүлэх ямар нэгэн дарамт байхгүй болсон байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Гэхдээ дээрх боломжийг дүүрэн ашиглаагүйгээр зогсохгүй хүйтэн дайны улмаас НҮБ-ын индэр эсрэг тэсрэг хоёр системийн үзэл суртлын тэмцлийн талбар болж Монгол Улс ч түүнд татагдан оролцож эхэлсэн юм.

Судлаач Р.Болд бүтээлдээ НҮБ-д БНМАУ-ыг элсүүлэх тухайд АНУ Чан Кайшийн Хятадтай бодлогоо хэрхэн зохицуулж ирснийг АНУ-ын Гадаад харилцааны эх сурвалжийг үндэслэн: Гадаад Монголын эсрэг хориг тавих нь түүнийг дэмжиж байсан олонхийн эсрэг хориг болж буй тул НҮБ-д Гоминьданы төлөөлөх эрх ноцтой хөндөгдөх болсон, Гадаад Монголоос шалтгаалж чөлөөт олон улсыг элсүүлэх боломжийг алдаж буй, БНМАУ-ыг татгалзах АНУ-ын үндэслэлгүй байр сууринаас түүний төлөөлөгч нь хүртэл залхаж байсан, Ази, Африкийн улсуудын Бандунгийн бага хурлын зөвлөмжид Монгол Улс өөрийгөө тусгуулж чадаагүй, Америкийн дэмжлэгээр оршин тогтнож байгаа хэрнээ түүний бодлогыг үл тоомсорлож байсан Чан Кайшид шахалт үзүүлэх болсон тухай өгүүлсэн байна. «АНУ Ар Монголыг дэмжиж санал өгөхгүй, Тайванийг дэмжсэн мэдэгдэл хийнэ, Кеннеди Чан Кайшид коммунист Хятадыг НҮБ-д оруулахгүй хориг тавих нотолгоог дипломат шугамаар өгнө, чингэвэл Тайвань Ар Монголд хориг тавихгүй» гэж тохиролцжээ. БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнээр элсүүлэхийг АНУ дэмжсэн нь түүний БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөх бодлогын үргэлжлэл байсан гэж дүгнэжээ.²² Чингэхлээр БНМАУ НҮБ-д гишүүнээр элсэхэд АНУ шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой байна.

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

АНУ дандаа ч эсэргүүцэж байгаагүй бөгөөд 1949, 1955, 1956 онд түгээмэл зарчмаар санал орж ирэхэд гурван ч удаа түдгэлзэж байжээ. БНМАУ ЗХУ-ын ангич байр сууринаас болж аль 1946 онд НҮБ-д элсэх алтан боломжоо алдсан байна.

Ким Ил-сон, Сталин, Мао Цзедун нарын шууд гардан зохион байгуулсан Солонгосын дайнд БНМАУ Хойд Солонгосын талд баттай зогсч, сэтгэл санаа, эд материалын үлэмжхэн тусламж үзүүлсэн, үүний хаялга НҮБ-д элсэх Монгол Улсын хүчин чармайлтыг олон жил хойш нь татахад нөлөөлсөн талаар огт хөндөж байгаагүй юм. Коммунист Хятад Солонгосын дайнд орсон үеэс хойш Чан Кайшигийн Хятад АНУ-ын тэргүүлсэн НҮБ-ын цэргийн ажиллагааг бүх талаар дэмжиж, НҮБ-ын АЗ-д байнгын маргаан үүсгэж байснаар зогсохгүй ЗХУ-ын «хүчээр булаан авсан Хятадын алдагдсан газар нутаг» болох Гадаад Монгол Хойд Солонгост цэрэг илгээсэн зэрэг илэрхий мушган гуйвуулсан баримт гаргаж байсан юм. 1950-иад онд АНУ-д коммунизмын эсрэг ялангуяа Хятадыг коммунистуудад алдсаны төлөө олон хүнийг буруутгасан маккартизмын дуулиан ид өрнөж байсан юм.

Байтаг Богдын хилийн мөргөлдөөнөөс шалтгаалан 1946-49 оны БНМАУ, Дундад улс хоёр элчин төлөөлөгч харилцан суулгаж чадаагүй, 1949 онд БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтсон, 1953 оны 2 дугаар сарын 15-нд Гоминьданы Хятад 1945 оны Зөвлөлт-Дундадын холбоотны гэрээ, түүний хавсралтуудыг хүчингүй болгосон зэрэг олон хүчин зүйлүүд ч нөлөөлж байсан билээ.

1961 оны 12 дугаар сард Нью-Йорк хотноо БНМАУ-ын Байнгын Төлөөлөгчийн газрыг нээв. Анхны Байнгын Төлөөлөгчөөр Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Баярын Жаргалсайхан томилогдож, 12 дугаар сарын 15-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга У Танд Итгэмжлэх захидлаа гардуулсан байна.

***De jure* хүлээн зөвшөөрсөн нь**

Нэгдсэн Вант Улсын Засгийн газар БНМАУ-тай харилцаагаа хэвийн болгох сонирхолтой байсан нь 1961 оны 7 дугаар сард Нэгдсэн Вант Улсын Лордын танхимын хэлэлцүүлгээс харж болно. «Хэрэв тус улс өөрөө хүсвэл Их Британий Засгийн газар нь Монголыг зөвшөөрөн хүлээхээс татгалзахгүй ба НҮБ нь БНМАУ-ыг гишүүнээр элсэхэд ч болох» тухай онцлон тэмдэглэжээ.²³

Өрнөдийн гүрнүүдээс БНМАУ-ыг ***de jure*** хүлээн зөвшөөрч

дипломат болон бусад харилцаа тогтоох үйл явц тус орныг 1961 оны 10 дугаар сард НҮБ-д гишүүнээр элсэн орсны дараа эхэлсэн бөгөөд **хамгийн түрүүнд Монгол Улстай Өрнөдийн томоохон гүрэн, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс албан ёсны харилцаа тогтоожээ.**

1962 оны 8 дугаар сарын 30-нд Ю.Цэдэнбал БНМАУ нь АНУ, Англитай дипломат төлөөлөгчид даруй солилцох уу гэсэн АНУ, Англи, ХБНГУ-ын сурвалжлагчдын асуултад бичгээр хариулахдаа: «Манай оронтой хэвийн харилцаа тогтоохыг сонирхогч орон бүхэнтэй харилцаа тогтоох эрмэлзэлтэй байгаагаа БНМАУ-ын Засгийн газар, Монголын хувьсгалт төр анх үүсэн тогтсон цагаас эхлэн илэрхийлсээр ирсэн юм. БНМАУ төрийн тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх, ялгаварлан гадуурхах ямар нэгэн үзэл гаргахгүй байх үндсэн дээр өрнө зүгийн орнуудтай, түүний дотор АНУ, Их Британи улстай хэвийн харилцаа тогтооход одоо ч гэсэн бэлэн байна» гэжээ.²⁴

Бээжин дэх БНМАУ-ын Элчин сайдын 1963 оны 1 дүгээр сарын 7-ны ноотод: «Цог Жавхланта Хатан Хааны Засгийн газар нь хэрэв БНМАУ-ын Засгийн газар хүсвэл тус хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг хэлэлцэхэд бэлхэн байгаагаа мэдэгдэх завшаан тохиолдов. Цог Жавхланта Хатан Хааны хэргийг хамаарагч нь үүнтэй холбогдсон бүх асуудлыг эрхэмсэг ноён Элчин сайдтай хэлэлцэх бүрэн эрх олгогдсон болно» гэсэн 1962 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ноотыг хүлээн авснаа нотлохын хамт «БНМАУ-ын Засгийн газар нь Цог Жавхланта Хатан Хааны Засгийн газраас тус хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох тухай асуудлыг хэлэлцэх хүсэлтэй байгааг ойлгож, хоёр улсын бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэх зарчим дээр үндэслэгдсэн ийм харилцааг тогтоох явдал бол тус хоёр орны хооронд сайн санаа, харилцан ойлголцох явдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр болох юм гэж үзэж баяртай хүлээн авч байна» гэж мэдэгджээ. Ноот солилцооны дагуу хийгдсэн хэлэлцээний дүнд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоож, элчин сайдын зэрэг бүхий дипломат төлөөлөгчдөө томилохоор тохиролцсон тухай мэдээ 1963 оны 1 дүгээр сарын 23-нд нийтэлжээ.²⁵

Нэгдсэн Вант Улс нь Өрнөдийн орнуудаас Монгол Улсыг 1963 онд анх удаа хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрч, Улаанбаатар хотод хамгийн түрүүнд 1965 онд ЭСЯ-аа нээсэн бол үүн лүгээ Монгол Улстай хамгийн түрүүнд худалдааны Хэлэлцээрийг Засгийн

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

газрын түвшинд анх удаа 1973 оны 3 дугаар сард Лондон хотноо байгуулжээ. Дурьдсан хэлэлцээрт Их Британийн талаас ГЯЯ-ны орлогч сайд А.Ройл, Худалдаа, үйлдвэрийн яамны орлогч сайд, Лорд хэргэмт Лимерк нар, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, Нэгдсэн Вант Улсад байнга суух анхны Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд С.Дамбадаржаа нар гарын үсгээ зуржээ.²⁶

Тийнхүү 8 жил хэлэлцсэний эцэст байгуулагдсан энэ Хэлэлцээр нь БНМАУ-аас Өрнөдийн томоохон гүрэнтэй Засгийн газрын түвшинд байгуулсан анхны хэлэлцээр болсноороо Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаа, дипломатын түүхэнд шинэ зүйл болсон гэж үзэж болох юм.

1968 онд Монгол-Английн худалдаа 183 мянган ам.доллар байсан бол 1969-73 оны хооронд 4 жилийн хугацаанд Монголын худалдаачид 3 удаа очиж, 1,8 сая. ам долларын аж үйлдвэрийн комбинат, мах комбинатын машин, техник, сэлбэг, химийн зарим бараа худалдан авчээ. Дурьдсан хугацаанд Лондоны ангийн үсний үнэ хаялцуулах [auction] худалдаанд Монгол Улс 5 удаа оролцож 2,6 сая ам.долларын чоно, үнэг, хярс, хэрэм, тарваганы арьс зэрэг бүтээгдэхүүн борлуулж байжээ.

Өрнөдөөс Их Британийн ЭСЯ Улаанбаатарт 1965 онд, Францын ЭСЯ 1966 онд нээгджээ. Монгол Улс МАХН-ын ТХ-ны УТТ-ны 37 тоот тогтоолын дагуу 1969 онд Лондон, Парист байнгын ЭСЯ-аа нээсэн нь НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн, Өрнөдийн хөгжингүй капиталист оронд ЭСЯ-аа нээсэн анхны тохиолдол болсон юм. Их Британид байнга суух анхны Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилогдсон С.Дамбадаржаа 1969 оны 11 дүгээр сарын 19-нд Цог Жавхланта Хатан Хаан II Елизабетэд ИЖБ-гээ барьснаар албан ёсоор ажилдаа оржээ. Дипломат харилцаа тогтоосны дараа тухайн үед хоёр оронд Монгол Улсын байнгын ЭСЯ байхгүй байсан учир Софид сууж байсан Монголын элчин сайд Дэлэгжунай Балжинням Нэгдсэн Вант Улсад хавсран суух элчин сайдаар томилогдож, 1963 оны 11 дүгээр сард Хатан хаанд анх ИЖБ-гээ барьж байжээ.

Нэгдсэн Вант Улс дахь ЭСЯ-ны үндсэн үүрэг нь: «МАХН-ын XV Их хурлаас тус улсын гадаад бодлогын талаар дэвшүүлж тавьсан ээлжит зорилтуудыг амьдралд хэрэгжүүлэх явдал мөн. Үүний тулд БНМАУ-ын энх тайванч гадаад бодлогын чиг шугам, интернациональч зарчмыг Англи болон Хойд Европын орнууд [Норвеги, Дани улсууд]-тай харилцах харилцаанд тууштай баримтлаж ажиллахын хамт тэдгээр орны гадаад, дотоод төрийн

бодлогыг байнга судлахад ЭСЯ-ны бүхий л үйл ажиллагааг чиглүүлбэл зохино... тэгш эрх, харилцан хүндэтгэх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр БНМАУ болон Английн хооронд тогтсон харилцааг улс түмний энх тайван, аюулгүй байдал, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын ашиг сонирхолд нийцүүлэн хэвийн хэмжээнд байлгах буюу цаашид хөгжүүлэх чиглэлээр санаачлан ажиллах...Лондон хот нь олон улсын худалдаа, санхүүгийн харилцааны томоохон зангилаа тул дэлхийн зах зээлийн үнэ, валют-санхүүгийн системд гарч байгаа өөрчлөлтийг ажиг бололцоотой мэдээллийг төвдөө өгч байх,... өөрийн оронд социализм байгуулах эрх ашигт Англи ба Хойд Европын хөрөнгөтөн орнуудын эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн зарим амжилтыг ашиглах зорилгоор тэдэнтэй үр ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх боломжийг ажиг, манай орны ардын аж ахуйд хэрэглэж болохуйц ашигтай туршлага, сайн техник, тоноглолыг хайж судлах» гэжээ.²⁷

Төгсгөл

1991 оны 7 дугаар сард Лондонд болсон Их долоо, ЕЭЗХН-ийн дээд хэмжээний уулзалтын баримт бичигт Монгол Улсад олон улсын тусламж үзүүлэх талаар заалт орсон юм. Дээд уулзалтад Их Британий Ерөнхий сайд Жон Мейжорын урилгаар ЗХУ-ын Ерөнхийлөгч М.С. Горбачёв анх удаа оролцсоноор 7+1 хэмээх бүтэц бий болжээ. Энэ зөвлөлгөөний шийдвэрийг үндэслэн Японы Засгийн газрын санаачлагаар Дэлхийн банктай хамтран Монголд хандивлагч орнуудын анхдугаар чуулга уулзалт 1991 оны 9 дүгээр сард Токиод зохиогдсон билээ.

ХБНГУ-ын Шинжлэх ухаан, бодлогын сангийн тэргүүлэх судлаач, доктор К.Мёллер «Герман улс Азид, Монгол Улс Европт» хэмээх өгүүлэлдээ: «Эн тэргүүнд чухалчилж үзсэн түншүүдийн дотор Герман нь нэгдүгээр байрыг хуваалцаж буй Орос, Хятад хоёр ба АНУ, Японы дараа дөрөвт орж байна. Европын бусад орон гэсэн зэрэглэлд мөн л Европын жижгэвтэр, сайхан сэтгэгдэл төрүүлэхүйц орнууд тухайлбал, Дани, Нидерланд, Финлянд, Австри, Швед, Швейцари улс багтаж байгаа бөгөөд тэднийг Энэтхэг, Өмнөд Солонгос, Тайланд, Сингапур, Туркийн араас байрлуулсан байна. ЕХ-г яг энэ нэрээр нь нэрлэж оруулаагүй бөгөөд мөн Франц, Их Британи, Итали улсыг ч мөн адил юм. Үүний үндэс шалтгаан нь гадаад худалдааны эргэлтэй холбоотой юм уу, эсвэл гашуун туршлагаас үүдэлтэй эсэхийг би мэдэхгүй юм. Харин Брюссель ч,

БНМАУ-ын ОУ-ын статусыг хүлээн зөвшөөрөх НВУ-ын бодлого

Лондон ч 1990-ээд оны дундаас Монгол дахь үйл ажиллагаагаа идэвхижүүлэхийг оролдож байгаа билээ» гэж²⁸ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалыг шүүмжлэнгүй бичжээ.

Үнэхээр 1994 оны «Гадаад бодлогын үзэл баримтлал»-д Монгол Улсын чухаг түнш Их Британи, Франц, Итали, Бельги болон ЕХ, Канад улсыг огт дурдалгүй орхигдуулсан юм.

Их Британи улс 1945 оны 2 дугаар сард Холбоотон гурван гүрний Ялтын бага хурлын үеэр байгуулсан нууц хэлэлцээрт АНУ-ын хамт гарын үсэг зурж, Гадаад Монголын status-quo-г хүлээн зөвшөөрч, 1961 онд НҮБ-д гишүүнээр элсэхэд Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүний хувьд «төлөө» саналаа өгч, 1963 онд Өрнөдийн их гүрнүүдээс анх удаа БНМАУ-ыг de jure хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоон, Өрнөдийн их гүрнүүдээс анх удаа 1965 онд Улаанбаатар хотод ЭСЯ-аа нээсэн бол 1973 оны 3 дугаар сард анх удаа Засгийн газрын түвшинд худалдааны хэлэлцээрийг байгуулсан юм. Монгол Улсын цөмийн зэвсгийн бүсийн санаачилгад Их Британи нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүний хувьд бусад гишүүн Франц, АНУ, ОХУ, БНХАУ-тай хамтран баталгаа гаргасан билээ.

P5 гэж нэрлэгддэг НҮБ-ын АЗ-ийн Байнгын тав буюу цөмийн зэвсэгтэй таван гүрний Байнгын төлөөлөгчид «Цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын талаарх хамтарсан Тунхаглал»-д, Монгол Улсаас НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгч О.Оч энэ статусын агуулгыг тодорхойлсон Тунхаглалд 2012 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Нью Йорк хотноо тус тус гарын үсэг зурсан юм. Английн Байнгын төлөөлөгч Мак Грант (Mark Lyall Grant) P5-ын нэрийн өмнөөс энэхүү арга хэмжээг нээж үг хэлэхдээ Цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын талаарх P5-ын хамтарсан тунхаглал болон Монгол Улсын тунхаглал нь дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан, цөмийн зэвсэгтэй гүрнүүд цөмийн зэвсэггүй орнуудтай хэрхэн хамтран ажиллах боломжтойг харуулсан, цөмийн зэвсгийг хорогдуулах үйлсэд хувь нэмэр оруулж байгаагаараа нэн ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэсэн билээ.

Их Британи бол Монгол Улсын бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын ЕХ-н дахь хамгийн том зах зээл бөгөөд 2011 оны байдлаар тус Холбооны гишүүн орнуудтай хийсэн нийт худалдааны 25 хувь, экспортын 38 хувь нь Их Британид ногдож байв. Монгол Улсаас Их Британид экспортлосон бүтээгдэхүүний 80 хувь нь цэвэршүүлсэн алт, 20 орчим хувь нь самнасан ноолуур

болж байв. Британийн хөрөнгө оруулалт Виржини арлуудыг оролцуулаад 140,3 сая ам. доллар, бүртгэгдсэн компанийн тоо 103 хүрч Монголд оруулсан хөрөнгө оруулалтын жагсаалтын 5-8 дугаарт орж, ЕХ-ны зөвхөн ТАСИС хөтөлбөрийн шугамаар Монгол Улсад үзүүлсэн тусламжийн 16 орчим хувийг Британийн тусламж эзэлж байв.

«Оюу толгойн» төслийн хөрөнгө оруулалтад дэлхийд хоёрт орох нэр хүндтэй, Лондонд бүртгэлтэй Их Британийн «Rio Tinto» үндэстэн дамнасан группын томоохон шууд хөрөнгө оруулалт орж ирэх боломжтой болсон билээ. Төсөл Монгол Улсад ашигтай хэрэгжвэл урьдчилсан байдлаар Монгол Улсын ДНБ ойролцоогоор 5 дахин өсч, ядуурлыг бууруулах, ажлын байрыг шинээр буй болгох, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болох яриа байсан ч гэрээнд хоёр талын эрх ашгийг тэнцүү тусгасан зүйл заалт оруулж яаралтай шинэчлэх шаардлагатай болсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс хоёр том гүрний дунд оршдог, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, буурай хөгжилтэй орон байсан бол эдүгээ хоёр аварга зааны дунд орших одой морьхон (pony, мөн galloper гэж хэлж болохоор), өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, геозэдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна.

Тиймээс «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд үүнийг харгалзан үзэх шаардлагатай болж байгааг тэмдэглэе.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1910-1914), УБ., 1982, 61 дэх тал

² БНМАУ-ын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. (1921-1961) I Боть, УБ., 1964, 6 дахь тал

³ FRUS. Diplomatic papers, The Conferences at Malta and Yalta. 1945, Washington, 1955. p. 379

⁴ «Соглашение о вступлении Советского Союза в войну против Японии»-Дипломатия в Годы Войны.: Woodrow Wilson International Center for Scholars, Washington, D.C. 1999-

2000

⁵ FRUS. Diplomatic papers, The Conferences at Malta and Yalta. 1945, Washington, 1955. p. 379

⁶ «Соглашение о вступлении Советского Союза в войну против Японии»-Дипломатия в Годы Войны.: Woodrow Wilson International Center for Scholars, Washington, D.C.

⁷ «Draft of Marshal Stalin's Political Conditions for Russia's Entry in the War against Japan»-FRUS Diplomatic papers, The Conferences at Malta and Yalta. 1945, Washington, 1955, p. 896

⁸ Ibid. FRUS

⁹ «Соглашение о вступлении Советского Союза в войну против Японии»-Дипломатия в Годы Войны.: Woodrow Wilson International Center for Scholars, Washington, D.C.

¹⁰ Memoirs of Winston Churchill. Boston.: Houghton Mifflin, 1963, vol. III, p. 390

¹¹ The Agreement of February 11, 1945, signed by Marshal Stalin, Prime Minister Churchill and President Roosevelt, was classified as Top Secret, and was titled «Agreement Regarding Entry of the Soviet Union into the War against Japan»- British and Foreign State Papers, 1947, Part II, vol.148 (London, Her Majesty's Stationery Office, 1955) pp. 88-89

¹² «Agreement Regarding Entry of the Soviet Union into the War against Japan, February 11, 1945» in US Department of States, FRUS. Diplomatic papers. The Conferences at Malta and Yalta, 1945 (Washington, D.C.: GPO,1955), p. 984

¹³ UN and Mongolia. Documents from the UN and Government archives. 2008, pp. 72-73

¹⁴ БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1921-1961. 1 боть, УБ., 1964, 109 дэх тал

¹⁵ UN and Mongolia. Documents from the UN and Government archives. pp. 42-46

¹⁶ Ibid., pp. 32-36

¹⁷ Пхамсүрэн Н. Дуртгал: “Эх орны бие даасан байдал”. «Монголын ажилчин» сонин. 1990.08.20

¹⁸ FRUS, 1947, Vol. I, 1949, Vol. II, UN, 1955-57, Vol. XI,

¹⁹ Уламбаяр Д. Монгол, Өрнөдийн орнуудын харилцаа: Эрт, эдүгээ. УБ., 2004, 94 дэх тал

²⁰ Церенцоодол П. Монгольская Народная Республика и Организация Объединённых Наций УБ., 1958, с. 70

²¹ FRUS. 1961, UN, 1961-63, Vol. XXII,

²² Болд Р. Монголын тусгаар тогтнол ба АНУ (1910-1973). УБ., 2008. 264-269 дэх тал

²³ ГХТА. Ф.28. Д.1. ХН.4. 27 дахь тал

²⁴ Осипов А.А. Внешняя политика МНР. М., 1963, стр. 81

²⁵ ГХТА. Ф.28. Д.1.ХН.10

²⁶ Дамбадаржаа С. Британий арал дээр Монгол гал голомт ассан нь. УБ., 1999, 84 дахь тал

²⁷ Дамбадаржаа С. 23 дахь тал

²⁸ Монгол-Германы харилцаа: Өнгөрсөн үе-эдүгээ-үе-хэтийн төлөв. УБ., 2004, 19-20 дахь тал

Abstract: This article underlines the position of the UK foreign policy towards Outer Mongolia's international legal status, in which how it has been changed and progressed starting from status quo recognition to collective recognition form de facto, and till de jure as well.

Key words: note, top secret agreement in Yalta, UN, Security Council, Permanent members of the UN, veto, status quo, de facto, de jure